

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хувь хэрэгжиж эхэлсэнтэй холбогдүүлэн шинэчлэн боловсруулсан
- Хувь тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба

Албан тушаалын нэр:

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын байрны албан ёсны байршил:

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, Нутгийн захиргааны 2 дугаар байр

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төрийн, орон нутгийн өмчийн байгууллагуудад Төсөв, санхүүгийн болон бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аймгийн Засаг даргыг бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх, агентлагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцан тайлагнана.

Албан тушаалын зорилт:

1. Дотоод аудит ба салбарын хяналт шалгалтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх.
2. Санхүүгийн хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах.
3. Дотоод аудитын үйл ажиллагаа, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.
4. Байгууллагын төсвийн хөрөнгө, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, хяналт тавих.
5. Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээг зохион байгуулах</p> <p>2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандартын хэрэгжилтийг зохион байгуулах</p>	<p>Хуульд нийцсэн, хэл зүй, найруулгын алдаагүй, ойлгомжтой байх.</p> <p>Үнэлгээг зохих аргачлалын дагуу хийсэн байх</p>	<p>Х, Ш</p> <p>Х, Г</p>
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах</p> <p>2.Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээ, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр дүн, санхүү, төсөв, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах</p> <p>3.Хяналт шалгалтын дүнд тулгуурлан хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж,</p>	<p>Үнэлгээг зохих аргачлалын дагуу хийсэн байх</p> <p>Хяналт шалгалт хуулийн дагуу хийгдсэн байх</p>	<p>Х, Ш</p> <p>Х</p> <p>Х</p>

	<p>шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох</p> <p>4.Хэрэглэгчдийг зөвлөмж, мэдээлэл, арга зүйгээр хангах</p>		
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Дотоод аудитын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах</p> <p>2.Хэрэглэгчдийг арга зүйгээр хангах, заавар зөвлөмж өгөх</p> <p>3.Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах</p>	<p>Хууль тогтоомжид заасны дагуу боловсруулж хэрэгжүүлсэн байх</p>	<p>Х, Ш</p> <p>Х, Ш</p> <p>Х, Ш</p>
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүү, бусад нөөцийн талаар санал, төсвийн төсөл боловсруулж, батлуулах.</p> <p>2.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;</p> <p>3.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэнд хяналт тавьж балансад байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж ашиглах</p> <p>4.Төсвийн болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулж, хяналт тавьж ажиллах.</p> <p>5.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлагналтад хяналт тавих.</p> <p>6.Төсөв санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;</p>	<p>Хууль тогтоомжид заасны дагуу төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлсэн байна</p>	<p>Г, Х, Ш</p> <p>Г, Х</p> <p>Х</p> <p>Х</p> <p>Х</p> <p>Х</p>
5 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах, дүгнүүлэх</p> <p>2.Байгууллагын албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангах, албан</p>	<p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд хангагдсан байна</p> <p>Байгууллагын болон мэргэжилтний үүрэг бүрэн</p>	<p>Х,Ш</p> <p>Г, Х</p>

	<p>тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн үйлчилгээг соёлтой шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх</p> <p>3. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх,</p> <p>4. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг хэрэгжүүлэх,</p> <p>5. Гадаадын ижил, төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, дэвшилтэд техник, технологийг ажилдаа нэвтрүүлэх арга хэмжээ авах</p> <p>6. Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, стандартыг хэрэгжүүлэх.</p> <p>7. Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>8. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, сургаж чадавхижуулах ажлыг зохион байгуулах</p> <p>9. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх</p>	<p>хэрэгжсэн байна.</p> <p>Хүний нөөцийн бодлогын асуудал хууль тогтоомжид нийцсэн байна.</p> <p>Стандартыг мөрдүүлсэн байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна</p> <p>Сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр хэрэгжсэн байна</p> <p>Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.</p>	<p>Г, Ш</p> <p>Г, Х</p> <p>Х, Ш</p> <p>Г, Х</p> <p>Х, Ш</p> <p>Г</p>
--	--	---	--

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
Мэргэжил	Санхүү, нягтлан бодох бүртгэл
Мэргэшил	<p>-Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх</p> <p>-Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч байх</p>
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх
Ур чадвар	<p>Удирдан зохион байгуулах</p> <p>-байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах шаардлага тавьж чаддаг байх;</p> <p>-удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг</p>

		<p>оновчтой тэнцвэртэй хуваарилах, удирдах;</p> <p>-үйл ажиллагаан дахь эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;</p> <p>-албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих;</p> <p>-албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, хуульд нийцсэн заавар чиглэл өгөх;</p> <p>-үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</p> <p>-бусад.</p>
	Дүн шинжилгээ хийх	<p>-судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлого боловсруулах;</p> <p>-тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх;</p> <p>-судалгааны үр дүн, шийдлийн хувилбарын шууд ба шууд бус үр дагаварыг харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулах;</p> <p>-бусад.</p>
	Асуудал шийдвэрлэх	<p>- хууль тогтоомжид нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах;</p> <p>-тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;</p> <p>-албан үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх;</p> <p>- бусад.</p>
	Манлайлах	<p>-ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх;</p> <p>-шинэлэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих;</p> <p>-байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;</p> <p>-аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгах;</p> <p>-хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</p> <p>-бусад.</p>
	Бусад	<p>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</p> <p>-албан бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөх;</p> <p>-мэдээллийг шуурхай хүргэх, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;</p> <p>-багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох.</p>
<p><b>IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</b></p>		

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн Засаг дарга

Албан тушаалд шууд харьяалан  
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Ахлах мэргэжилтэн ....

Мэргэжилтэн ....

Төрийн үйлчилгээний албан хаагч .....

Нийт ..... /тоо/

Бусад харилцах субъект

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

-Сумдын Засаг дарга

-Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга

-Төрийн болон төрийн өмчит байгууллага

-Иргэн, хуулийн этгээд


**У.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 /О.МӨНХБАЯР/

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 09 дүгээр сарын 13 -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 2019.09.13

Дугаар: 63

**VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

Байгууллагын нэр:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019.10.09

Дугаар: А/349

(тамга/тэмдэг)

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА.....

  
(Гарын үсэг)

/Ш.ОРГИЛ/

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 10 дугаар сарын 09 -ний өдөр